

**"ДАРХАН НЭХИЙ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 03 дугаар сарын 29-ны өдөр

дугаар № 01

Дархан-Уул аймаг

"Дархан нэхий ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Дархан нэхий ХК-ийн үйлдвэрийн байрны хурлын танхимд 2025 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 12⁰⁰ цагт нийт 931,146,839 ширхэг хувьцаатай, хувьцаа эзэмшигчид оролцсоноор 84.23%-ийн ирцтэйгээр хурлыг хийлээ.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

1. Б. Дагвацэрмаа	29 087 000 ш
2. Э. Батсайхан	326 903 000 ш
3. Б. Гэрэлмаа	7 800 000 ш
4. Ж. Пүрэвсүрэн	50 000 ш
5. Р. Сүмбэнхүү	218 097 075 ш
6. "ННТТ" ХХК	349 209 764 ш

Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс томилсон тухай шийдвэрийг танилцууллаа.

П. Энхжин Тооллогын комиссын дарга

-Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын бүртгэлийг хуулийн дагуу хийж, ирцийг мэдээлж, санал өгөх зааврыг танилцуулав. Тэрээр хувьцаа эзэмшигчид энэхүү хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр санал өгөхдөө батлагдсан саналын хуудас №1-ээр, ТУЗ-ийн гишүүдийг сонгож санал өгөхдөө батлагдсан саналын хуудас №2-оор тус тус бичгээр өгнө. Харин ТУЗ-ийн гишүүнийг сонгох саналыг Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 09 сарын 09-ны өдрийн 880 тоот тогтоолоор шинэчлэн баталсан "Санал хураах кумулятив арга хэрэглэх журам"-ыг баримтлан санал өгнө гээд уг журмыг тайлбарлан танилцууллаа.

Хурлын дарга Э. Батсайхан:

-Хувьцаа эзэмшигчдийнхээ хуралд хүрэлцэн ирсэн Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхэндээ талархал илэрхийлж, мэндчилье.

-Тооллогын комиссын мэдээллээр хуралд оролцох Хувьцаа эзэмшигчдийн ирц 84.23%-тай байгаа тул хурлын ирцийг хангалттай гэж үзэж хурлаа эхлүүлж байна гээд хурлын дэгийг танилцуулав.

-Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээж байна. Өнөөдрийн хурлаар 6 асуудлыг хэлэлцэнэ. Одоо хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулья.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн тухай хуулийн 96.4-д заасан тайланг танилцуулах
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгож батлах
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг батлах
5. Ноогдол ашиг хуваарилах, эсэх тухай ТУЗ-өөс гаргасан шийдвэрийг танилцуулж, батлах
6. Толгой компанийн хувьцаанаас охин компаниуд зөвшөөрсөн хэмжээгээр эзэмшихийг зөвшөөрч, батлах

Хэлэлцсэн нь:

Хурлын дарга Э. Батсайхан Хувьцаа эзэмшигчдэд, компанийн өнөөгийн байдлын талаар товч мэдээлэл өгч, хурлын хэлэлцэх асуудалд оров.

1-р асуудал:

Э. Батсайхан /хурлын дарга/

-Дархан нэхий ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ээс өгсөн дүгнэлтийг тайлбарлан танилцууллаа. ТУЗ энэхүү дүгнэлтийг Компанийн -Бүтэц, зохион байгуулалт, -Үндсэн үйл ажиллагааны чиглэл, -Хөрөнгө, -Зээл, -Өр төлбөр, -Компанийн удирдах ажилтнуудад олгосон шагнал урамшуулал, -Цаашид анхаарах зүйлс гэсэн 8 хэсэгт ангилан дүгнэснийг тус бүрээр нь дэлгэрэнгүй танилцууллаа. Тэрээр Эздийн өмч 60 тэрбумаас 66 тэрбум болж 9.92% өсжээ. Эргэлтийн бус хөрөнгө 47% эзлэж, хөрөнгийн өгөөж дөнгөж 1 хувь орчим байгаа сайжруулах шаардлагатай бөгөөд компанид ашиглалтгүй эргэлтийн бус 1,5 тэрбум орчим төгрөгийн хөрөнгө, хуучин бараа бүтээгдэхүүн 12 тэрбум зэрэг үнэ цэнэ тогтмол буурч буй хөрөнгүүдийг яаралтай хямдруулан зарж борлуулан идэвхтэй актив болгоход анхаарч ажилласан. Өнгөрсөн жил 12 тэрбум шахам бараа материалыг 8 удаагийн тушаал шийдвэрээр 30-70% хямдруулан зарж борлуулан 5 тэрбум шахуу төгрөгийн орлого олсон нь хангалтгүй байна. Мөн ашиглалтгүй хөрөнгүүдийн тооллого хийж зарж борлуулан эргэлтэд оруулах ажил зохион байгуулж ажиллснаар 22,34 сая төгрөгийн хөрөнгө материал зарж борлуулжээ. Тайлант хугацаанд нийт 1,902 тэрбум хөрөнгө оруулалт, 462,44 сая төгрөгийн барилгын засвар үйлчилгээ хийж хөрөнгө сайжруулах ажил хийгдсэн байна. 50 гаруй жил ашиглагдсан барилга байгууламж дорвитой их засвар шаардлагатай болсон нь цаашид энэ чиглэлд анхаарч хөрөнгө гаргах шаардлагатай нь харагдаж байна. 9,1 тэрбумаас 7,8 тэрбум болж 1,3 тэрбумаар буурсан. Урт хугацаат өр төлбөр 4,1 тэрбумаас 1,5 тэрбум болж 2,6 тэрбумаар тус тус буурсан нь санхүүгийн өрийн дарамт багсаж байгаа сайн талтай байна. Зээл 4,7 тэрбумаас 1,37 тэрбум болтлоо буурсан. Өр төлбөрийн дийлэнх хувийг татварын өр 5,58 тэрбумаас 5,69 тэрбум болж өссөн бөгөөд энэ хугацаанд 6,8 тэрбум төгрөгийн татвар шинээр нэмэгдэж 6,69 тэрбум төгрөгийн татвар төлсөн нь компани дөнгөж тайлант хугацаанд үүссэн татварын өрөө л төлсөн байдалтай байна. Цаашид компанийн ашиг орлого нэмэгдэж, зардал буурахын хирээр урсгал өрөөтөлөх санхүүгийн чадвар нэмэгдэх боломжтой. Үйлчилгээний Гранд як ХХК, санхүү, лизингийн Дэвжих нэхий ББСБ-уудын удирдлагатай хийсэн үр дүнгийн гэрээг дүгнэж ТУЗ-ийн тогтоолоо төгрөгийн шагнал урамшуулал олгосон. Бусад компанийн удирдлагууд үр дүнгийн шагнал урамшуулал аваагүй. 2024 онд Дэвжих нэхий ББСБ-ийн удирдлагын гэрээний дагуу ажил дүгнэж 63,588 сая төгрөгийн урамшуулал, Гранд як ХХК-ийн ажлыг дүгнэж 184,368 сая төгрөгийн урамшуулал олгосон. Үүнээс удирдлагад Дэвжих нэхий ББСБ 42,1 сая, Гранд як ХХК удирдлагад 107,4 сая төгрөг ноогдож бусад нь ажилтнуудын 13-р сарын цалин, шагнал урамшуулалд зарцуулагджээ. Ялангуяа толгой компани болох Дархан нэхий ХК-ийн зүгээс санхүүгийн хяналт тавих, үйл ажиллагааны гүйцэтгэл дүгнэж хариуцлага тооцох, ажилтнуудыг хариуцлагажуулах, үүрэгжүүлэх, үр дүнг тооцох ажил хангалтгүй явагдаж ирлээ. Цаашдаа хяналтын фүнхц бүхий энэ завсрын ерөнхий удирдлагын үйл ажиллагааг санхүү хяналтыг үүргийг ТУЗ-н аудитийн хороонд, гүйцэтгэх удирдлагуудын ажлын гүйцэтгэл дүгнэх үүргийг ТУЗ-ийн НДХороонд шилжүүлэлэн ТУЗ-өөс охин компаниудтай шууд холбоос үүсгэж ажиллах нь илүү үр дүнтэй болно гэж тооцож байна. ТУЗ-ийн аудитын хороо

энэ хугацаанд санхүү хяналтын үүргээ биелүүлээгүй орхигдуулснаас санхүүгийн дотоод хяналт, шалгалтийн ажил орхигдсон байгаад анхаарч ТУЗ-д мэргэжлийн үр чадвартай хүмүүсийг татан оролцуулах, хяналтыг тогтмолжуулах шаардлагатай. Үр ашиг багатай зардал ихтэй компанийн зарим нэг уламжлалт бүтээгдэхүүн үйлчилгээнээс зоригтой салж, шинэчлэлтийг гүнзгийрүүлэх шаардлага байсаар байна.

2-р асуудал:

КтХ-ийн 96.4-д заасан ТУЗ-ийн ажлын тайланг хурлын дарга бөгөөд ТУЗ-ийн дарга, Э. Батсайхан танилцууллаа.

Э. Батсайхан:

- Өнгөрсөн жилийн байдлаар УЦ-ны 68 компани дээр, 5470 хувьцаа эзэмшигч байсан бол 2025.03.10-ны бүртгэлээр УЦ-ны 72 компани дээр, 6146 хувьцаа эзэмшигч байна. Хувьцаа эзэмшигчийн тоо 676 хүнээр нэмэгдсэн байна. ТУЗ-ийн 2024 оны төсвийн талаар мэдээлэе, төсвөөр: 107,837,562₮, гүйцэтгэл: 77,975,024₮, зөрүү: 29,842,348₮. ТУЗ-ийн гишүүдийн ажлыг дүгнэх журам гарган батлаж, сар бүр ажлыг дүгнэж төсвөөр биш гүйцэтгэлээр санхүүжилт тооцдог болсонтой холбоотой ТУЗ-ийн төсөвт зардлын хэмнэлт гарсан. 2024 оны эцэст 12,900,383 төгрөгийн үлдэгдэл гарсан нь эхний 2 сард Гранд як ХХК, Дэвжих нэхий ХХК-аас төсвөөр санхүүжилт авсантай холбоотой. Энэ мөнгөний үлдэгдлийг санхүүгийн дотоод аудит хийх зардалд зориулна. ТУЗ-ийн дотоод ажлын хувьд Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо, аудитын хороо гэсэн хоёр үндсэн хороотой, хороо болгон үйл ажиллагааны журам, гишүүдийн ажил дүгнэх журам гарган мөрдөж ажилласан. 2024 онд ТУЗ 15 удаа цахим болон танхимаар хуралдсан. Мөн ТУЗ 58 тогтоол, шийдвэрийг гарган хэрэгжүүлсэн байна. 2024 онд ХНХ-ын өмнө 11 тогтоол шийдвэр гаргасан бол ХНХ-аас томилогдсон шинэ ТУЗ-өөр 47 тогтоол шийдвэр гаргажээ. Энэ хугацаанд ТУЗ-өөс гаргасан бодлогын баримт бичгүүд, үйл ажилааны чиглэл дараах үндсэн асуудалд төвлөрч ирлээ. Үүнд: -Компаниудын санхүүгийн чадварыг сайжруулах, үйлдвэрлэлийг оновчлох, зардлыг бууруулах, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, -Компаниудын төсөв төлөвлөгөөг ажиллах хүчний нөөц, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн нарийвчлан гаргуулж батлан биелэлтэд хяналт тавих. -Компанийн боловсон хүчний хомсдлыг багасгах, ажилтнуудын урт хугацааны тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх, ТУЗ-өөс компаниудын тайланг хэлэлцэн, бүтцийг цомхон болгох арга хэмжээг авч ажиллалаа. -Компанид бүтцийн өөрчлөлт хийж Оёдлын үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэр, худалдаа гэсэн 3 үндсэн чиглэлтэй болгон 9 захирлын орон тоог 4 болгож, худалдааны чиглэлээр 2 орон тоо нэмж үүрэг багатай орон тоонуудыг цомхотгох арга хэмжээ авсны үр дүнд Компанийн ажилчдын орон тоо 250-аас 201 болж 20% буурсан. -Компанийн санхүү бүртгэлийн ажлыг удирдлагын бүртгэлд шилжүүлэх ажлыг эхлүүлж, өгөгдлийн санг коджуулан бүртгэх ажил эхлэв. Бүртгэлийг төрөлжүүлэн 9 ерөнхий нягтланг үйлдвэрлэлийн, худалдааны гэсэн 2 чиглэл болгон хариуцуулж бүртгэлээр нь дагнан хариуцсан НБДБА 3, ДБША 2 болгон өөрчилж төрөлжсөн бүртгэлийг автоматжуулах чиглэл өгч ажилласны үр дүнд бүртгэл тооцооны ажил сайжирсан. -Үйлдвэрлэлийн нэгжүүдийг багийн тогтолцоонд оруулах ажил хийж, хариуцлагажуулах ажлыг хийж хэвшүүлэх ажил явагдаж байна. Компаниудын удирдах ажилтнуудын ажил үүргийн хуваарь ажил дүгнэх үзүүлэлтүүдийг тодорхой болгон хариуцлагажуулж гэрээг шинэчлэн хийлгэх ажил хийгдэв. Жилийн байдлаар үйлдвэрлэл 17% тасарсан буюу 82% биелэлттэй, борлуулалт 31% тасарсан буюу 69% биелэлттэй. Зардал 69% биелэлттэй. Ашиг -48% буюу төлөвлөгөөт алдагдлыг 58% бууруулж ажилласан харагдаж байна. -Шинээр орон тоо нэмэхгүй бүтээмжийг сайжруулах ажлыг энэ өөрчлөлтийн хүрээнд хийснээр ажилчдын цалин ажилчдын дундаж цалин 37% өсөлттэй, удирдлагын цалин 19% буурсан, санхүүгийн ажилтнуудын дундаж цалин 4% өссөн, ИТА нарын дундаж цалин 8% өссөн дүнтэй байна. Цалингийн дундаж 1,425 сая болж өмнөх оноос 400 мянган төгрөгөөр өссөн. Цаашид дундаж цалинг үйлдвэрлэлийн ажилтнууд 3 сая, худалдаа үйлчилгээний ажилтнуудынх 2 сая болж өсгөх зорилт тавьсан. -Ажиллах хүчний хомсдолтой холбоотой ажиллах хүчний тогтвор суурьшлийг хангах зорилгоор ажилтнуудын цалинг гүйцэтгэлтэй нь уялдуулан бүтээмжийн өсөлтөөр нэмэх бодлого гарган хэрэгжүүлж ажилтнуудын дундаж цалинг жил бүр шат дас дараатай өсгөх чиглэл гаргаж ажиллаж байна. -Дархан нэхий ХК-ийн ажилтнуудын урт хугацааны тогтвор суурьшлийг хангах, ажлынхаа үр ашгас хүртдэг болгох зорилгоор Дархан нэхий ХК-ийн ажилтнуудад эзэмшүүлсэн хувийг нэмэгдүүлэх асуудлыг ТУЗ-д гарган эзэмшлийн хувийг 18,12%-наас 30 хувь болгон өсгөх зорилгоор 11,87% нэмж авах шийдвэр гаргууллаа. -Компанийн гүйцэтгэх удирдлагуудын ажил үүргийн хуваарийг гарган баталгаажуулж, цалин хөлсийг үр дүнтэй нь уяж өглөө. НДШ -ийг бууруулах, ажилтнуудын залгамж халааг бэлтгэх зорилгоор ахмад ажилтнуудыг татан оролцуулах чиглэл өгч ажиллаж байна. -Ахмадын сан, хамтын гэрээний нөхцлийг шинэчлэн тогтоов. Ашиглалтгүй, хөрөнгүүдийн тооллого хийж, хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцох ажил хийгдэх эхэлсэн бөгөөд цаашид энэ ажлыг 2025 онд багтааж шийдвэрлэнэ. Энэ ажлын хүрээнд ашиглалтгүй компаниудын талбайн түрээсийг нягтлан гаргаж, үл хөдлөх хөрөнгүүдийн ашиглалтыг сайжруулах чиглэл гарган ажиллаж байна. Мөн олон жил засвар үйлчилгээ хийгдээгүй үйлдвэрлэлийн цехүүд, барилгын урсгал болон их засваруудын ажлыг төсөвлөн батлуулж, ажлын байрны орчин нөхцлийг сайжруулах ажлыг хийж гүйцэтгэх ажил хийгдэж, 180-р цехийн дотоод засвар, туршилтын цехийн дэвээр, контор, хонгилийн засвар, Дархан их дэлгүүрийн фасад, бизнес төвийн дэвээр, эвент холлын иж бүрэн засвар зэрэг тохижилтын ажлыг төсөв батлан хийлгэсэн. Цэвэрлэх байгууламжийн ажлыг сэргээж механик цэвэрлэгээ, бороожуулалтыг хийж цэвэрлэх байгууламжийг эхний ээлжийн байдлаар засварлуулж үйлдвэрлэл явуулах эхний нөхцлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллаа. Нэхий таннери ХХК: хөрөнгө оруулалтын төсөв 248 сая төгрөг, засвар 108,79 төгрөг, гүйцэтгэлийн хувь 47-100%, Оёдол: засвар 31,5 сая, хөрөнгө оруулалт 15,78 сая, зарах хөрөнгө 15 сая зарсан 8,6 сая. Нэхий трейд: 46,457 сая засвар, 11,7 сая хөрөнгө оруулалт, зарах 6,5 сая, зарсан 2,5 сая, Гранд як хөрөнгө оруулалт 1,62 тэрбум, засвар 275,7 сая, зарсан хөрөнгө 11,24 сая. Дэвжих 6,89 сая хөрөнгө оруулалт. Нийт 1,902 тэрбум хөрөнгө оруулалт, 462,44 сая төгрөгийн засвар, 22,34 сая төгрөгийн хөрөнгө ақлан заржээ. 12 тэрбум шахуу хуучин барааны үлдэгдлийг үнэ хямдруулан шахан борлуулж хөрөнгө суллах ажлыг Ерөнхий захирлын шууд удирдлагын доор хариуцуулан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласнаар 8 удаагийн хямдралаар 5 тэрбум орчим бараа зарж борлуулжээ. Бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, хөгжүүлэлт хийж чанартай цөөхөн барааг үйлдвэрлэх чиглэл барьж үйлдвэрлэлийн төлөвлөгөөг гарган ажиллаж байна. Хэрэгцээгүй, чанарын шаардлага хангахгүй бараа үйлчилгээнээс татгалзах бодлого хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд туршилт технологи, загвар сайжруулалтын талаар гадаадын түншүүдтэй хамтран ажиллах эхлэлүүд тавигдсан. Мөн үйлдвэрлэлийг захиалгат үйлдвэрлэлд шилжүүлэх чиглэл өгсөн. Борлуулалтыг захиалгат, гэрээт хэлбэрт шилжүүлэх бодлого гарган хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ онд тодорхой үр дүн гарна гэсэн хүлээлттэй байна. Борлуулалтын зардлыг бууруулах, борлуулалтыг нэмэгдүүлэх шаталсан арга хэмжээг борлуулалтын компанийн удирдлагатай хамтран авч хэрэгжүүлж байна. Өндөр хүүтэй зээлүүдийг урдчилан төлүүлэх, компани хоорондын өр авлагыг барагдуулах ажилд анхаарч ажилласны үр дүнд нийт 3,517 тэрбум төгрөгийн зээл барагдуулж, Голомт банкны репо зээл 860 сая, Азийн хөгжлийн банкны 145 сая төгрөгийн зээл, ББСБ-ийн 370 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлээс бусдыг барагдуулах ажлыг хийж зээл 4,7 тэрбумаас 1,37 тэрбум болтлоо буурсан. Нийт өр төлбөр 9,1 тэрбумаас 7,8 тэрбум болж 1,3 тэрбумаар буурсан. Урт хугацаат өр төлбөр 4,1 тэрбумаас 1,5 тэрбум болж 2,6 тэрбумаар тус тус буурсан нь санхүүгийн өрийн дарамт багсмаж байгаа сайн талтай байна. Өр төлбөрийн дийлэнх хувийг татварын өрээлэж байгаа бөгөөд 5,58 тэрбумаас 5,69 тэрбум болж өссөн бөгөөд энэ хугацаанд 6,8 тэрбум төгрөгийн татвар шинээр нэмэгдэж 6,69 тэрбум төгрөгийн татвар төлсөн нь компани дөнгөж тайлант хугацаанд үүссэн татварын өрөө л төлсөн байдалтай байна. Цаашид анхаарах гол зүйлүүд: Олон жил засвар үйлчилгээ хийгээгүй учир бороо усанд идэгдэн үйлдвэрийн барилга байгууламжуудын хана нурах, дэвэрээс ус гоожих зэрэг хүндрэлүүд үүссэн учир засварын ажлууд нилээд хийгдэх шаардлагатай. Үйлдвэрлэлийн зарим нэг чиглэлүүдийг нэмэх, шинээр тоног төхөөрөмж авах, автоматжуулахтай холбоотой Цагаан Алт хөтөлбөрийн хүрээнд хөрөнгө оруулалтын болон эргэлтийн хөрөнгийн зээл авах асуудлыг бүрэн шийдвэрлэх. Цэвэрлэх байгууламжийн иж бүрэн засварыг хийж, усны дахин ашиглалт хийх, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг ашиглах чиглэлд анхаарч ажиллах нь зүйтэй болж байна. Энэ зорилгоор компаниудын элэгдлийн санг тусгаарлаж, ашиглалтгүй хөрөнгүүдийг зарж борлуулах, ашгийн үлдэгдлээс хөгжлийн сан байгуулж засвар үйлчилгээг үе шаттайгаар хийхэд онцгой анхаарах хэрэгтэй. Тайланд ТУЗ-ийн зүгээс бодлогын чанартай гэхээс илүү зарим нэг аж ахуйн ажлууд тусгагдан орсон нь яах ч аргагүй татвар төлбөрөө төлж чадахгүй дансаа хаалгах, үйлдвэрийн бохирдол ус цэвэрлэгээгүй нийлүүлэгдэж цэвэрлэх байгууламжаа зогсоох ноцтой асуудлууд тулгарсан байснаас зарим нэг тулгамдсан асуудлуудад хутгалдан орохоос өөр арга байсангүй. ТУЗ-ийн дүгнэлт болон ТУЗ-ийн тайланг танилцууллаа. Хувьцаа эзэмшигч та бүгдээс асуух зүйл байна уу.

Ж. Пүрэвсүрэн: Хувьцаа эзэмшигч

-Тайлан, дүгнэлтийг маш сайн ил тод байдлаар дэлгэрэнгүй танилцууллаа гэж бодож байна. Энэ үйлдвэрийг улсын нэр хүнд бүхий том үйлдвэр гэж бодож явдаг. Экспортод бараа бүтээгдэхүүнээ гаргах хэрэгтэй. Шинэ зүйл хийх хэрэгтэй Ерөнхийлөгчийн бизнес аялалд оролцсон уу. Компанийн гүйцэтгэх захирал энэ хуралд оролцож байгаа юу. Бусад компаниуд гүйцэтгэх захирал тайлан тавьж байдаг. Энэ миний л бодол. Юу хийдэг компани вэ.

Э. Батсайхан:

-Гүйцэтгэх захирал Гэрэлмаа энд байна. Гранд як нь Зочид буудал, худалдаа үйлчилгээний компани.

Ж. Пүрэвсүрэн:

-Би 1991 онд 50 ширхэг хувьцаа авч байсан. Энэ маань одоо 50,000 ширхэг болсон байна. Нарийн учрыг мэдэхгүй байна. Би жирийн л хүн. Одоо 20-иод компанийн хувьцаа эзэмшдэг. ДНХК-ийн ТУЗ алдаа, оноо, өр авлага бүхий л зүйлийг ил тод тайлагналаа. Цаашдаа шинэлэг юм хийх хэрэгтэй санагдлаа. Зауучуудыг анхаарч ажиллуулах

Э. Батсайхан:

-Санхүүгийн ажлыг сайжруулах шаардлага байна. Хуучин барааны үлдэгдэл их байсныг үнэ хямдруулан борлуулж, агуулахын үлдэгдлийг бууруулах, дотоод хяналт ажиллуулах, өр төлбөр барагдуулах зэрэг ажлууд байна. Мөн шахмал шир, тэлээний үйлдвэрийн төсөл зогссон байгаа. Эдгээрийг хөдөлгөх хэрэгтэй. Залуучууд тавьж үзсэн.

Ж. Пүрэвсүрэн:

-Бизнес аялалд оролцсон компаниуд, шинэ зүйл их хэрэгжүүлж байна гэж харсан. Удирдлага зохион байгуулалт муу байна. Улсын хамгийн том үйлдвэр. Шинэлэг зүйл хийх. Шагнал, урамшууллыг яаж олгосон бэ.

Э. Батсайхан:

-Ер нь бид зах зээлээ алдсан гэдгийг өмнө ч хэлсэн. Ашигтай ажилласан компанийхандаа Хөдөлмөрийн гэрээний заалтаар урамшууллыг олгосон. Удирдлага-5%, ажилчид 15%. Аялал 13 дахь сарын цалин бүгд багтсан байгаа.

Р. Сүмбэнхүү:

-Би хөрөнгө оруулагчаар удаж байна. Олон хүн ярилцаж байж шийдвэрийг гаргаж ажилладаг. Хуулийн дагуу бодитой тайлан гарч явдаг. Соц үеийн үйлдвэр учир нээлттэй байдаг. Гадаад дотоодод тэр үедээ нэр хүндтэй байсан. Монгол хонины арьсны хөрс зузаан. Олон улсын стандартын шаардлага хангахгүй байна. ТУЗ тайланг зөв үнэлсэн гэж үзэж байна.

Э. Батсайхан:

-ТУЗ-ийн тайлантай холбоотой санал байна уу? За санал, асуулт, тодруулах зүйл байхгүй бол дараагийн асуудлыг хэлэлцье.

3-р асуудал:

Э. Батсайхан: Хурлын дарга

-ТУЗ-ийн гишүүнийг сонгож, батлах асуудлыг хэлэлцье. ТУЗ-д нийтдээ 10 иргэн нэр дэвшсэн бөгөөд үүнээс ТУЗ-ийн ердийн гишүүнд 5 иргэн, хараат бус гишүүнд 5 иргэн тус тус нэр дэвшсэн байна. Нэр дэвшигчдийн анкет, хараат бус гишүүний шалгуурыг хангасан эсэх талаархи мэдээллийг нэр дэвшигч тус бүрээр товч танилцууллаа. ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал өгөхдөө шинэчлэн баталсан санал хураах кумулятив арга хэрэглэх журам"-ын дагуу өгөхийг дахин санууллаа.

Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх ба тэдгээрийн 5 нь ердийн, 4 нь хараат бус гишүүн байна. Саналын хуудсаар нэр дэвшигчдэд санал өгч, хуудсыг тооллогын комисст хүлээлгэн өгнө. Одоо дараагийн асуудалд орё.

4-р асуудал:

ТУЗ-ийн дарга Э. Батсайхан ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал 2025 оны ТУЗ-ийн зардлын төсвийг өмнөх онуудын төсөв гүйцэтгэлийг тус тус танилцуулав. 2025 оны ТУЗ-ын төсвийн нийт зардлыг 108,477,372 төгрөгөөр тусгасаж төлөвлөсөн болно. Өмнө оны ТУЗ-ийн төсөв хэмнэгдэж ирсэн байгаа.

5-р асуудал,

-Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн 2025 оны 02 сарын 14-ны өдрийн 25/05 тоот тогтоолыг уншиж ТУЗ-ийн дарга Э. Батсайхан танилцууллаа.

6-р асуудал:

Э. Батсайхан

-Компанийн хувьцаа нэмж авах тухай ТУЗ-ийн 2024 оны 12 сарын 26-ны өдрийн 24/46 тоот тогтоолыг танилцуулж, Толгой компанийн хувьцаанаас охин компаниуд зөвшөөрсөн хэмжээгээр эзэмших талаар тайлбарлан танилцууллаа.

Хурлын дарга 5, 6-р асуудалтай холбоотой санал байгаа эсэхийг хувьцаа эзэмшигчдээс асууж тодруулахад асуулт байсангүй. Иймд энэ хурлаар хэлэлцэх асуудал хэлцэгдэж дууссан байна. Та бүхэн саналын хуудсаа бөглөхгөөнө үү.

Хуралд оролцогч хувьцаа эзэмшигчдийн бөглөсөн саналын хуудсыг тооллогын комисс хүлээн авч, дүгнэн дүнг танилцуулж, Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 01, 02, 03 шийдвэрийг тооллогын комиссын дарга П. Энхжин танилцууллаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналын дүн:

1.Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг батлах, Компанийн тухай хуулийн 96.4-д заасан ТУЗ-ийн тайлантай танилцсаныг батлах, ТУЗ -ийн гишүүн сонгох асуудлыг батлах, ТУЗ-ийн 2025 оны зардлын төсөв батлах, Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-аас гаргасан шийдвэртэй танилцсаныг батлах, Толгой компанийн хувьцаанаас охин компаниуд зөвшөөрсөн хэмжээгээр эзэмшихийг зөвшөөрч батлах, шийдвэр гарсныг тус тус танилцуулав.

2.ТУЗ-ийн гишүүдийг сонгох саналын дүн:

Санал хураалтаар доорхи 9 гишүүнийг ТУЗ-ийн гишүүнээр сонгож, үүнээс ердийн гишүүнд 5, хараат бус гишүүнд 4 гишүүн сонгогдсон тухай дүнг танилцуулав.

1.ТУЗ-ийн ердийн гишүүнээр:

1. Эрдэнэдалайн Батсайхан - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 84 хувийн саналаар;
2. Равжаагийн Сүмбэнхүү - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 84 хувийн саналаар;
3. Баасан Гэрэлмаа- Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 84 хувийн саналаар;
4. Батсайханы Мягмар-Өлзий - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 84 хувийн саналаар;
5. Ганхуяг Ган-Очир - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 84 хувийн саналаар;

2. ТУЗ-ийн хараат бус гишүүнээр:

1. Тогоо Дансран - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 84 хувийн саналаар
2. Мягмардорж Ганзориг - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 84 хувийн саналаар;
3. Лувсандорж Гүнчин - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 84 хувийн саналаар;
4. Ринчин Бямбадорж- Хуралд оролцогчдын 96% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 81 хувийн саналаар;

Компаний хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 03 дүгээр сарын 29-ны өдрийн хуралдаанаас дараах шийдвэрийг гаргалаа.

Хурлын шийдвэр:

1. Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн тухай хуулийн 96.4-д заасан ТУЗ-ийн тайланг танилцуулахыг батлах
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгож батлах
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг батлах
5. Ногдол ашиг хуваарилах, эсэх тухай ТУЗ-өөс гаргасан 2025 оны 02 сарын 14-ны өдрийн 25/05 тоот тогтоолд тусгагдсан шийдвэрийг зөвшөөрч батлах
6. Толгой компанийн хувьцаанаас охин компаниуд зөвшөөрсөн хэмжээгээр эзэмшихийг зөвшөөрч, ТУЗ-ийн 2024 оны 12 сарын 26-ны өдрийн 24/46 тоот тогтоолд тусгагдсан Компанийн хувьцааг нэмж авах тухай шийдвэрийг батлах

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТАНИЛЦСАН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ХУРЛЫН ДАРГА



Х.НАРАНТУЯА

Ө.БАТСАЙХАН